



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Japan
Fund for
Poverty
Reduction



**L3605/G9191:MON48076 - ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ,
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ**

**ХҮҮХДИЙН ХӨДӨЛГӨӨН ЗАСАЛ, ХӨДӨЛМӨР
ЗАСЛЫН СЕРТИФИКАТЫН СУРГАЛТ
(ЦАХИМ СУРГАЛТ)**

Аутизмын хүрээний эмгэг / Мэдрэхүйн
мэдээллийг боловсруулах эмгэгтэй
хүүхдийн эмчилгээ

2022 оны 2 сарын 24

Ширли Цэ

Хонг-Конгийн хөдөлмөр засалч


Агуулгын тойм

- Хүн-Хөдөлмөр-Орчин-Гүйцэтгэл (PEOP) загварт суурилсан цогц арга барил бүхий эмчилгээний танилцуулга
- Эмчилгээний зарчим, стратегийн танилцуулга
- Өдөр тутмын тогтсон цагийн хуваарь тогтоох стратегийн талаарх ойлголт
- Эдгээрийг жишээ тохиолдолд тулгуурлан тайлбарлана

Хүн-Хөдөлмөр-Орчин-Гүйцэтгэл (PEOP) загвар

1. Хөдөлмөр, хүн, орчин гэсэн гурван хүчин зүйлийн **давхцал их байх** тусам гүйцэтгэл **сайн** байна.
2. **Хүчин зүйл бүр** нь тухайн хүний эмгэг өөрчлөлтийн байдлаас хамааран **динамикаар өөрчлөгддөг**.

Жишээ нь: Хүнд хэлбэрийн эмгэг → Орчин, хөдөлмөрийг тохируулах шаардлага илүү их гарна.



Цогц арга барил бүхий эмчилгээ: PEOP

- Хийх үйлдлийг жижиг алхмууд болгон задлах
- Тухайн хүний оновчтой чадварт хүрэхийн тулд даалгаврыг тохируулах

Дэмжлэгийг нэмэгдүүлж, орчны саад бэрхшээлийг арилгах

1. Тухайн хүний давуу талд тулгуурлан үйлдлийн үр чадварт сургах
2. Зан байдлыг зохицуулах нь өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлдөг



PEOP загварт тулгуурласан эмчилгээний стратегийн зарчмууд

1. Түүний үйлдэл, оролцооны **чадварыг (давуу талыг)** тодорхойлох
2. **Тоглох үед** тэдний **сонирхлыг** юу татаж байгааг олж мэдээрэй
3. **Сонирхлыг** нь хийх **үйлдэлтэй** нэгтгэх
4. Хэвшмэл зан байдлыг **утга учиртай үйлдэл** болгоход дэмжлэг үзүүлэх
5. Хүүхдийн бие **зохион байгуулалттай байдалд орж, тэр байдлаа барьж байхад** шаардагдах мэдрэхүйн өдөөлтийг хүүхдэд өгөх мэдрэхүйн үйлдлүүдийн **хувь хүнд тохирсон хуваарийг** төлөвлө.
 - ✓ Хийх үйлдлүүдэд **проприоцептив болон вестибуляр** оролтыг хослуулах
 - ✓ **Жижиг алхмуудад** хувааж, **аажмаар** нэвтрүүлнэ
 - ✓ Түүний **дуртай** үйлдлийг давтан хийлгэ
6. Хүүхэд болон эцэг эхийг **“БИ ХИЙЖ ЧАДНА”** гэсэн туршлагатай байлгах

Хөдөлмөр засал эмчилгээний нийтлэг хэлбэрүүд

Мэдрэхүйн өрөөнд мэдрэхүйн нийлэмж



Нарийн жижиг хөдөлгөөнд сургах



Өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох чадавхийг бэхжүүлэх



Нийгмийн ур чадвар, танин мэдэхүйн сургалт



Жишээ тохиолдол (дүрс бичлэг)

- Нэр: Лок, 6 настай, эмэгтэй
- Эмээ, ээж, аав, охин дүүгийн хамт амьдардаг.

Жишээ тохиолдол

- Нэр: Лок, 6 настай, эмэгтэй
- **АХЭ-ийн түвшин** - хязгаарлагдмал, давтагдсан зан байдал нь ямар ч орчинд ажиллахад ихээхэн саад учруулдаг, өөрчлөлтөд маш их хямардаг.
- Зөвхөн дуу авиа гаргана, ярьж чадахгүй
- Сургуульд сурдаггүй

1. Хөгжлийн үе шат:

- Том үений хөдөлгөөний чадвар - 3 настай хүүхдийн хэмжээнд;
- Гараар юм хийх чадвар – 2 орчим настай хүүхдийн хэмжээнд
- Танин мэдэхүй - дунд зэргийн оюуны бэрхшээл (болзошгүй)

2. Тоглох ур чадварын хөгжил:

- Үйл ажиллагааны тоглоом -- мэдрэхүйн оролт бүхий шалтгаан ба үр дагавартай тоглоом
- Нийгмийн тоглох ур чадвар – Ганцаараа тоглодог

Жишээ тохиолдол

3. Мэдрэхүйн боловсруулалтын хэмжүүр үнэлгээний хариу:

- **Үйл ажиллагааны тодорхой алдагдлууд:**

- Нийгмийн оролцоо: хүнд хэлбэрийн алдагдалтай, шаардлагатай үедээ л харилцааг эхлүүлдэг
- Хараа: Хайгч (харж суралцагч)
- Сонсгол: Ердийн
- Хүрэлцэх: дунд зэргийн алдагдалтай, ус шиг бүтэцтэй зүйлийг хайгч
- Биеэ мэдрэх (проприоцепц): Хайгч
- Тэнцвэр ба хөдөлгөөн (вестибуляр): Хайгч
- Хөдөлгөөний төлөвлөлт ба санаачилгэ: хүнд хэлбэрийн алдагдал

Лок-оос илэрч буй шинж тэмдгүүд:

Мэдрэхүйн боловсруулалтын эмгэг, танин мэдэхүйн боломжийн чадвар бүхий хүнд хэлбэрийн АХЭ-ийн шинж тэмдэгтэй: хязгаарлагдмал, давтагдсан зан байдал нь ямар ч орчинд ажиллахад ихээхэн саад учруулдаг, өөрчлөлтөд маш их хямардаг

Хэвшмэл зан байдлын зохицуулалт нь ЛОК-ийн үйл ажиллагаанд нөлөөлдөг



Хэвшмэл зан байдлын шалтгааныг олж тогтоох:

1. Мэдрэхүйн боловсруулалтын эмгэг
2. Сэтгэлийн түгшүүрийг арилгах сэтгэлзүйн хэрэгцээ
3. Дургүй зүйлээсээ зайлсхийж, дуртай зүйлээ олж авах
4. Утга учиртай үйлдэл хийх чадавхийг бэхжүүлэх

Эмчилгээний зорилго

Илэрч буй шинж тэмдэг: Мэдрэхүйн боловсруулалтын эмгэг, танин мэдэхүйн боломжийн чадвар бүхий хүнд хэлбэрийн АХЭ-ийн шинж тэмдэгтэй:

➤ хязгаарлагдмал, давтагдсан зан байдал нь ямар ч орчинд ажиллахад ихээхэн саад учруулдаг, өөрчлөлтөд маш их хямардаг

• **Богино хугацааны зорилго (4-6 сар)**

- **Гэртээ байх үедээ** урьдчилсан сануулгатайгаар өдөр тутмын үйл ажиллагааны хооронд шилжихийг зөвшөөрдөг болох

- Эцэг эхийн дунд зэргийн тусламжтайгаар хүнсний ногоо, эсвэл жимс түүх, шүдээ угаах гэсэн **хоёр үйлдлийг** хийж чаддаг болно

• **Урт хугацааны зорилго (9-12 сар)**

- **Гэртээ болон сургалтын төвд** урьдчилсан дохио авч үйл ажиллагаа болон хүмүүсийн хооронд шилжихийг зөвшөөрөх

- Эцэг эхийн **бага ба дунд зэргийн** тусламжаар өдөр тутмын тогтсон дэглэм бүхий **бүх үйлдлийг** гүйцэтгэх чадвартай болно.

Цогц арга барил бүхий эмчилгээ: PEOP

- Хийх үйлдлийг жижиг алхмууд болгон задлах
- Тухайн хүний оновчтой чадварт хүрэхийн тулд даалгаврыг тохируулах

Дэмжлэгийг нэмэгдүүлж, орчны саад бэрхшээлийг арилгах

1. Тухайн хүний давуу талд тулгуурлан үйлдлийн үр чадварт сургах
2. Зан байдлыг зохицуулах нь өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлдөг



Лок-ийн хэвшмэл зан байдлыг түүний **сонирхож, хийж чадах утга учиртай үйлдэл** болгоход туслах.

Дэгдээхэйнүүдийг хооллох:
хараа болон сонсгол

Хүрэлцэх: шувууны хоол



Түмпэн дэх ус: Проприоцевтив (хүндийн жин), хараа болон хүрэлцэхүй

Усалгаа: Проприоцевтив (савын шахах), харах мэдрэхүй



Хийх үйлдэл (хөдөлмөр) –ийг жижиг алхмууд болгон задлах

- Хүнсний ногоо түүж, цэвэрлэж байна (Дүрс бичлэгээр үзүүлэв)



1. Ногоо түүнэ



2. Том түмпэнд ус хийнэ




3. Ногоог угаана



4. Усыг асгана

Лок ямар алхмыг хамгийн бага бодит тусламжтайгаар хийж чадах вэ?


Хийх үйлдэл (хөдөлмөр) –ийг жижиг алхмууд болгон задлах



Girl Potty Schedule

Мэдрэхүй хөдөлгөөний дуртай үйлдлүүд - мэдрэхүйн олон оролт



Энгийн алхмууд, богино хугацаа, эхлэх болон дуусах цагийг тодорхой зааж өгөх зэрэг өөрт нь тохирсон үйлдэл хийх боломж олгох  **БИ ЧАДНА ГЭСЭН** туршлагатай болно



Videos shown



Өөрт нь тохирсон өдөр тутмын тогтсон дэглэм






















- Эцэг эхийн оролцоог дэмжинэ:

1. Гэр бүлийн өдөр тутмын хэв маягийг хүндэтгэж тэдний **одоо байгаа түвшингээс** эхэлдэг
2. Хуваарь гаргахдаа эцэг эхчүүдтэй **хамтран ажилладаг**
3. **Гэрт байгаа зүйлсийг** ашигладаг (нэмэлт юм худалдаж авах шаардлагагүй)
4. Хүүхдийг татан оролцуулахын тулд **өөртөө итгэлтэй** (>70% амжилттай хийдэг) үйлдлийг сонгодог
5. **Асуудлыг шийдвэрлэх арга замаар** эцэг эхчүүдийн дэмжих чадварыг сайжруулдаг
6. Даалгаврыг **жижиг алхмуудад** задалж, хялбараас нь эхэл
7. Хүүхдийг **бага**, идэвхтэй оролцоход **явцын үед** анхаарлаа хандуулж, **үр дүнд** нь нэг их санаа зовох **хэрэггүй**

Daily Routine

Name LOK Primary Carer: _____ Relationship: _____

Time	Daily Routine					
AM	Wake up					
	toileting		-Moderate physical assistance: toilet -Mild physical assistance: wash hands			
	Grooming				-Moderate physical assistance: brush teeth & comb hair -Verbal prompt: clean the face	
	Dressing				-Moderate physical assistance: clothes, pants, socks & shoes -Verbal prompt: Jacket	
	Breakfast			Verbal prompt: pick the own spoon and bowl		
	Activity (indoor/ outdoor)	Vestibular & proprioception 	Hands skills training 	Visual & hear 	Hands & cognition training 	Wash hands skills  
	Lunch					



- **Харааны дохионы дэмжлэг**
 - цагийн хуваарь
 - хүртээмжтэй орчин: хийх зүйл нь тодорхой байх, бодит болон харааны хил хязгаарыг тодорхой байхаар зохион байгуулах
- **Хүртээмжтэй орчин**
- **Урам өгөх**
 - хүүхдийг үр бүтээлтэй зан байдал гаргасанд нь урамшуулах, өсөж хөгжиж байгаад нь дэмжлэг үзүүлэх нь
 - зан байдлыг нэмэгдүүлнэ
- **Тодорхой, урьдчилан таамаглах боломжтой заавар өгөх нь**
 - шилжилтийн үеийн түгшүүрийг бууруулна

Энэ хичээлээс сурсан зүйлс

- Гүйцэтгэлийг оновчтой болгохын тулд Хүн-Хөдөлмөр-Орчны хүчин зүйлсийг динамик байдлаар харах
- Хүүхдийн мэдрэхүйн хэрэгцээ, танин мэдэхүйн чадварыг хангах таатай орчныг бүрдүүлэх
- Өдөр тутмын үйл ажиллагаанд оролцуулахдаа жижиг бөгөөд яг тохирсон сорилттой алхмуудаас эхлэх
- Эцэг эхчүүдтэй нягт хамтран нөхөрлөл хэлбэрээр ажиллах
- Оролцогч талуудад (хүүхэд, эцэг эх, ажлын баг) амжилттай туршлагыг бий болгох

Баярлалаа!

